



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО, БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ (1995-2017 он)


УЛААНБААТАР

2018 ОН

1.1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл 1995 оноос Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо, бүртгэлийг хөтөлж гаргах болсон¹. Монгол Улсын Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан мэдээгээр 2017 онд төрийн албанд 192.5 мянган хүн ажиллаж байгаа нь 1996 онтой харьцуулахад 51.5 (36.5%) мянган хүнээр нэмэгдсэн байна.

Зураг 1. Төрийн албан хаагчид, мянган хүнээр, 1996-2017 он



Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

Төрийн албанд ажиллагчид 2017 онд 1996 оноос 51.5 мянгаар нэмэгдсэний 0.8 мянга нь улс төрийн албаны ажиллагчид, 11.0 мянга нь захиргааны албаны ажиллагчид, 13.5 мянга нь тусгай албаны ажиллагчид, 26.2 мянга нь үйлчилгээний албаны ажиллагчид байна.

Хүснэгт 1. Төрийн албан хаагчид, мянган хүнээр, 1996-2017 он

	1996	2000	2004	2008	2012	2016	2017
Бүгд	141.0	139.0	121.8	144.0	162.8	189.0	192.5
Төрийн улс төрийн алба	2.6	2.6	2.5	2.7	2.8	3.0	3.4
Төрийн захиргааны алба	8.0	7.8	9.3	13.1	16.2	19.0	19.0
Төрийн тусгай алба	23.9	29.6	23.0	25.7	28.8	37.0	37.4
Төрийн үйлчилгээний алба	106.5	99.0	87.0	102.6	115.0	130.0	132.7

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

¹ Монгол Улсын Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх тойм

Төрийн албанд ажиллагчдын тоо 1996-2000 онд 2.0 мянга, 2000-2004 онд 17.2 мянгаар буурсан хэдий ч 2004-2008 онд 22.2 мянга, 2008-2012 онд 18.8 мянга, 2012-2016 онд 26.2 мянга, 2016-2017 онд 3.5 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

Төрийн албанд ажиллагчдын тоо буурахад 1996 онд эхэлсэн өмч хувьчлал, эмч, багш нарын цалин хангамж бага байсан, мөн төрийн үйлчилгээний албанд ажиллаж байсан ерөнхий үйлчилгээний ажиллагчдыг гэрээт ажилтанд шилжүүлсэн зэрэг нь нөлөөлсөн байж болох талтай.


Төрийн албан хаагчид 2004-2008 онд 22.2 мянгаар нэмэгдсэний 15.6 мянга нь төрийн үйлчилгээний албанд, 2.7 мянга нь тусгай албанд, 3.8 мянга нь захиргааны албанд, 0.1 мянга нь улс төрийн албанд нэмэгдсэн байна.

2008-2012 онд 18.8 мянгаар нэмэгдсэний 12.4 мянга нь төрийн үйлчилгээний албанд, 3.1 мянга нь тусгай албанд, 3.1 мянга нь захиргааны албанд, 0.2 мянга нь улс төрийн албанд нэмэгдсэн байна.

2012-2016 онд 26.2 мянгаар нэмэгдсэний 15.0 мянга нь төрийн үйлчилгээний албанд, 8.2 мянга нь тусгай албанд, 2.8 мянга нь захиргааны албанд, 0.2 мянга нь улс төрийн албанд нэмэгдсэн байна.

Төрийн албан хаагчдын тоо 2016-2017 онд 3.5 мянгаар нэмэгдсэний 2.7 мянга нь төрийн үйлчилгээний албанд, 0.4 мянга нь төрийн тусгай албанд, 0.4 мянга нь улс төрийн албанд нэмэгдсэн байна.

Зураг 2. Төрийн албан хаагчид, ангиллаар, дүнд эзлэх хувь, 1996-2017 он




Төрийн албан хаагчдын бүтцээс харахад төрийн үйлчилгээний албан хаагчид 70 орчим хувь, төрийн тусгай албан хаагчид 20 орчим хувь, үлдсэн 10 гаруй хувийг төрийн захиргаа болон улс төрийн албан хаагчид эзэлж байна.

1.2. УЛС ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Улс төрийн албан хаагчид 2017 онд 3.4 мянгад хүрсэн байна. Улс төрийн албан хаагчдын тоо 1996-2004 болон 2014-2016 онд харьцангуй тогтвортой байна. Харин 2008-2012, 2012-2013, 2013-2014 онд тус бүр 100 хүнээр, 2016-2017 онд 400 хүнээр нэмэгдсэн байна.


Зураг 3. Улс төрийн албан хаагчид, мянган хүн, 1996-2017 он



Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

“Төрийн албаны тухай” хуулинд 2008 онд өөрчлөлт орсон бөгөөд Монгол Улсаас гадаад оронд суугаа элчин сайдын албан тушаал болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн албан тушаалын 33 хүнийг Төрийн тусгай албан тушаалын ангилалд шилжүүлж, улс төрийн албан хаагчдын тоог бууруулсан хэдий ч улс төрийн албан тушаалтны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан болон бүх шатны засаг дарга нарын тоог 2005-2016 онд 535-аар нэмэгдүүлсэн байна.

Зураг 4. Төрийн захиргааны албан хаагчид, мянган хүн, 1996-2017 он



Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

Төрийн захиргааны албан хаагчдын тоо 2017 онд 19.0 мянгад хүрч, 2004 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд яам, агентлагийн тоо жилээс жилд буурах хандлагатай байна.

Зураг 5. Яам, агентлагийн тоо, 1996-2017 он



Эх үүсвэр: ТАЗ, 2016 оны үйл ажиллагааны товч тайлан

Яам, агентлагийн тоо 1996 онд 68 байсан бөгөөд үүнээс 9 яам, 59 хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлаг байсан байна. Яамны тоо 2012 онд 16, агентлагийн тоо 28 байсан бөгөөд өнгөрсөн 2016 оны сонгуулийн дараа яамны тоо 13, агентлагийн тоо 27 болсон байна.

Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 14-р тогтоолоор 11 байсан яамдын тоог 5-аар нэмж 16 болгон баталсан. Ингэхдээ Хөгжил шинэтгэлийн улсын хороо гэдэг нэртэй тохируулагч агентлагийг Эдийн засгийн хөгжлийн яам болгон өөрчилж, олон төрлийн чиг үүргийг 1 яаманд нийлүүлсэн олон чиг үүрэгтэй 4 яам байгааг чиг үүргээр нь салгасан байна. Ингэхдээ Эрдэс баялаг эрчим хүчний яамыг Эрчим хүчний яам, Уул уурхайн яам болгон, Зам тээвэр барилга хот байгуулалтын яамыг Зам тээврийн яам, Барилга хот байгуулалтын яам болгон, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам болгон, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яамыг Боловсрол шинжлэх ухааны яам, Соёл спорт аялал жуулчлалын яам болгон тус тус чиг үүргээр нь салгажээ.

Эдийн засгийн хөгжлийн яамыг нэмснээр Засгийн газрын тохируулагч агентлагийн тоо 11 болж буурчээ. Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газар, Ойн газар, Усны газар, Соёл урлагийн хороо, Авто тээврийн газар, Төр засгийн үйлчилгээ аж ахуй эрхлэх газар, Төмөр замын газар, Эрүүл мэндийн газар гэх мэт Засгийн газрын 14 хэрэгжүүлэгч агентлагуудыг яамдууд руу шилжүүлэх, төрийн өмчийн үйлдвэрийн газар болгон хувиргах, заримыг нь хувьд шилжүүлж болно гэж үзсэнээр 31 хэрэгжүүлэгч агентлагийн тоог 17 болж буурсан.

Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3-р тогтоолоор 16 байсан яамдын тоог хоёроор цөөлж, ерөнхий чиг үүргийн яамны тоог нэгээр нэмэгдүүлж 6 болгож, чиглэлийн 7 яамтай байхаар Засгийн газрын бүтцийг баталсан байна. Хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны чиг үүргийг нэгтгэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болгон өөрчилж тус яамыг ерөнхий чиг үүргийн яамны бүтцэд нэмж оруулжээ.

Аж үйлдвэрийн яамыг татан буулгаж, чиг үүргийг нь өөр яамд болон агентлагт хуваарилах байдлаар өөрчлөлт оруулсан. Өмнөх Засгийн газрын 15 яамнаас 7 яамны чиг үүргийг нэгтгэх, өөрчлөх замаар 5 яам болгон өөрчлөн байгуулсан нь яамдын ажиллагчид өмнөх оноос буурах шалтгаан болжээ.

Хүснэгт 2. Яам, агентлагийн албан хаагчдын тоо

	Яамдын ажиллагчдын тоо	ЗГ-ын тохируулагч агентлагийн ажиллагчид*	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагийн ажиллагчид*	Дүн
2014	1521	529	2154	4204
2015	1567	499	1919	3985
2016	1539	483	1918	3940

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

*Төрийн тусгай албаны байгууллагуудад ажиллагчид /агентлаг/-ын тоо ороогүй.


Засгийн газрын тохируулагч агентлагийн тоо 2016 онд 10 болж 2012 оныхоос 1-ээр буурсан. Засгийн газрын тохируулагч агентлагт ажиллагчид 2015 оноос 16-аар буурсан бөгөөд энэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт 4 орон тоо, Стандартчилал, хэмжил зүйн газарт 4 орон тоо, Төрийн өмчийн хорооны 56 орон тоо хасагдаж Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт 4 орон тоо, Үндэсний хөгжлийн газарт 42 орон тоо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 2 орон тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг 2016 онд 17-оор баталсан. Ингэхдээ өмнө байсан Хөрөнгө оруулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Оюуны өмчийн газар, Тахарын ерөнхий газар, Газрын тосны газар гэсэн 5 агентлагийн нийт 315 орон тоог татан буулгаж, чиг үүргийг нь өөр агентлагт шилжүүлэн нэгтгэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Биеийн тамир, спортын газар, Соёл урлагийн газар гэсэн 3 агентлагийн нийт 322 орон тоог шинээр байгуулсан байна.

1.3. ТӨРИЙН ТУСГАЙ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ


Төрийн нийт албан хаагчдын 10 орчим хувийг төрийн тусгай албанд ажиллагчид эзэлж байна. Төрийн тусгай албанд ажиллагчдын тоо 1996 онд 23.9 мянга байсан бол 2000-2004 онд 23.0 мянга хүрсэн бол түүнээс хойш аажим нэмэгдсээр 2017 онд 37.4 мянгад хүрсэн байна.

Зураг 6. Төрийн тусгай албан хаагч, мянган хүнээр, 1996-2017 он



Төрийн нийт албан хаагчдын 70 орчим хувийг төрийн үйлчилгээний албанд ажиллагчид эзэлж байна. Төрийн үйлчилгээний албанд ажиллагчдын тоо 1996 онд 106.5 мянгаас 2000-2004 онд 87.0 мянга хүртэл буурч байсан бол түүнээс хойш тасралтгүй нэмэгдсээр 2017 онд 132.7 мянгад хүрсэн байна.

Зураг 7. Төрийн үйлчилгээний албан хаагч, мянган хүнээр, 1996-2017 он



Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

*2007 оноос өмнө төрийн үйлчилгээний ангилалд хамаарах албан хаагчдын тоог ерөнхий дүнгээр гаргаж байжээ.


Төрийн үйлчилгээний албанд ажиллагчдын 43.6 хувийг ерөнхий үйлчилгээ, 32.7 хувийг бага дунд боловсрол, 15.2 хувийг эрүүл мэндийн байгууллагад ажиллагчид тус тус эзэлж байна.

Зураг 8. Төрийн үйлчилгээний албанд ажиллагчид, ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2008-2017 он



Төрийн үйлчилгээний эрүүл мэндийн байгууллагад ажиллагчдын тооны өөрчлөлттэй уялдуулан эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан болон их эмч нарын тоонд дараах өөрчлөлт орсон байна.

Зураг 9. Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан болон их эмч нарын тоо, мян.хүн, 2008-2017 он



Их эмч нарын тоо 2008-2017 онд 2992-оор нэмэгдсэн байна. Их эмч нарын тооны нийт өсөлтийн 62.4 хувь буюу 1867 нь нийслэлд байгаа бол үлдсэн 37.6 хувь буюу 1125 нь аймгуудад ногдож байна. Тухайлбал, 2008-2012 онд их эмч нарын тоо 1013-аар нэмэгдсэн байна. Тэдгээрээс хамгийн олон их эмч нэмэгдсэн аймаг нь Говь-Алтай аймагт 36, Ховд аймагт 45, Дорнод болон Өмнөговь аймагт тус бүр 26 их эмч нэмэгдсэн бол Улаанбаатар хотод 797 их эмч нэмэгдсэн байна. Нэг их эмчид ногдох хүний тоо 2008 онд 349 байсан бол 2017 онд 293 болж 56-гаар буурсан байна.

Хүснэгт 3. Шинээр ашиглалтанд оруулсан ЕБС, цэцэрлэг, соёлын төв, спорт заал, эрүүл мэндийн байгууллагын тоо, 1992-2017 он


Он	ЕБС	Цэцэрлэг	Эрүүл мэндийн байгууллага	Соёлын төв	Спорт заал	Музей	Номын сан	Театр
2008	2	-	56	6	28	-	-	-
2012	4	16	52	-	34	1	-	-
2016	8	28	51	4	44	-	-	-
2017	8	24	20	1	51	-	1	-
Дүн	22	68	179	11	157	1	1	-

*Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
Эрүүл мэндийн яам*


1.4. ТӨРИЙН АЛБАНД АЖИЛЛАГЧДЫН ХУВИЙН ЖИН

Монгол Улсын төрийн албанд ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 1996 онд 18.3 хувь, 2000 онд 17.2 хувь, 2004 онд 12.8 хувь, 2008 онд 13.8 хувь, 2012 онд 15.4 хувь, 2016 онд 16.5 хувь байсан. Төрийн албанд ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 1995-2017 оны хооронд дунджаар 15.5 хувь байгаа бол 2017 онд 15.2 хувьтай тэнцүү байна.

Зураг 10. Төрийн албанд ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь, 1995-2017 он




Зураг 11. Төрийн албанд ажиллагчдын нийт хүн амд эзлэх хувь, 1995-2017 он



Монгол Улсын төрийн албанд ажиллагчдын нийт хүн амд эзлэх хувь 1996 онд 6.3 хувь, 2000 онд 5.8 хувь, 2004 онд 4.9 хувь, 2008 онд 5.4 хувь, 2012 онд 5.8 хувь, 2016 онд 6.2 хувь байсан. Төрийн албанд ажиллагчдын нийт хүн амд эзлэх хувь 1995-2017 оны хооронд дунджаар 5.7 хувь байгаа бол 2017 онд 6.1 хувьтай тэнцүү байна.

Зураг 12. Төрийн албанд ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь, сонгосон улс орнуудаар, 2015 он



Төрийн албанд ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 2015 онд Финланд, Швед, Дани улсад 24.9-30.0 хувьтай байгаа нь сонгосон улс орнуудын түвшинд хамгийн өндөр хувийн жинтэй байна. Харин Япон, Өмнөд Солонгос, Герман, Туркийн хувьд Төрийн албанд ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 5.9-12.4 хувь байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Сонгосон 16 улсын хувьд дундаж утга тооцоход эдгээр улс орнуудын түвшинд Төрийн албанд ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь 2015 онд 16.2 байгаа нь Монгол улс дундаж түвшинд байгааг илтгэж байна.

ДҮГНЭЛТ

Төрийн албан хаагчдын тоо нь 2017 оны байдлаар Монгол Улсын нийт ажиллагчдын 15.2 хувь, нийт хүн амын 6.1 хувьтай тэнцүү байна.

Төрийн албан хаагчдын тоо 2008 оноос хойш жил бүр нэмэгдэж, 2017 онд 192.5 мянгад хүрсэн байна. Төрийн албанд ажиллагчдын 132.7 мянга (68.9%) хувь нь төрийн үйлчилгээний албанд, 37.4 мянга (19.4%) нь төрийн тусгай албанд, 19.0 мянга (9.9%) нь төрийн захиргааны албанд, үлдсэн 3.4 мянга (1.8%) нь төрийн улс төрийн албанд ажиллаж байна.

Төрийн албанд ажиллагчид 2017 онд 1996 оноос 51.5 мянгаар нэмэгдсэний 0.8 мянга нь улс төрийн албаны ажиллагчид, 11.0 мянга нь захиргааны албаны ажиллагчид, 13.5 мянга нь тусгай албаны ажиллагчид, 26.2 мянга нь үйлчилгээний албаны ажиллагчид байна.

Улс төрийн албанд ажиллагчдын төрийн нийт албан хаагчдад эзлэх хувийн жин 1996-2017 оны хооронд харьцангуй тогтвортой байсан бол төрийн захиргааны албанд ажиллагчдын болон төрийн тусгай албанд ажиллагчдын хувийн жин өсөж, төрийн үйлчилгээний албанд ажиллагчдын хувийн жин буурсан байна.

Төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт нь харьцангуй тогтвортой бус, сонгуулийн 4 жил тутамд өөрчлөгдөж байсан. Яамдыг салгах, нийлүүлэх, нэршлийг солих, агентлагийн харьяаллыг өөрчлөх зэрэг хөдөлгөөнийг сонгууль болгоны дараа, 2012 оноос хойш 5 удаа хийсэн байна. Бүтцийн өөрчлөлтийн улмаас төрийн албан хаагчдын хөдөлгөөн нэмэгдэж, төрийн албаны тогтвортой байдалд нөлөөлөх болсон.

Хүн амын хэтийн 2015-2045 оны шинэчилсэн тооцооны дунд хувилбараар (МУ-д оршин суугаа хүн амаар тооцсон) хүн ам 2045 онд 2016 оныхоос 2.1 дахин, тэр дундаа ерөнхий боловсролын сургуульд суралцах насны хүүхдийн тоо 2.0 дахин, цэцэрлэгийн насны хүүхдийн тоо 2.3 дахин, ахмад настны тоо 2.0 дахин өсөхөөр байгаа нь цаашид боловсрол, эрүүл мэндийн салбарт төрийн үйлчилгээний ачаалал нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

Төрийн албан хаагчдын тоог оновчтой тогтоохын тулд хүн амын тооны бүтэц, өөрчлөлт, хөдөлгөөн, эрүүл мэндийн, боловсролын болон ерөнхий үйлчилгээний байгууллагуудын хүрэлцээ, хүчин чадал, багтаамж, төрийн албан хаагчдын ур чадвар, чадавхийг

нарийвчлан судлах шаардлагатай. Нөгөөтэйгүүр салбаруудын онцлог, бодлого, хөтөлбөртэй уялдуулан гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

Цаашид төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг чанд мөрдөж, төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, тогтвортой байлгах шаардлагатай байна.

Хавсралт 1. Төрийн албан хаагчид, ангиллаар, 1995-2017

№	Он	Нийт төрийн албан хаагчийн тоо	Төрийн албан хаагчид, ангиллаар			
			Улс төр	Төрийн захиргаа	Төрийн тусгай	Төрийн үйлчилгээ
1	1995	141 467	2 350	7 296	20 587	111 234
2	1996	141 022	2 562	8 023	23 895	106 542
3	1997	137 604	2 630	8 104	24 314	102 556
4	1998	131 878	2 729	8 303	23 709	97 137
5	1999	135 391	2 615	7 809	20 716	104 251
6	2000	139 062	2 648	7 801	29 603	99 010
7	2001	132 934	2 532	7 898	22 102	100 402
8	2002	140 419	2 500	9 300	29 150	99 469
9	2003	126 525	2 725	8 160	22 842	92 798
10	2004	121 760	2 531	9 284	23 006	86 939
11	2005	120 581	2 564	9 463	22 739	85 815
12	2006	128 088	2 727	9 940	24 105	91 316
13	2007	140 258	2 600	10 503	25 428	101 727
14	2008	144 049	2 704	13 104	25 688	102 553
15	2009	148 223	2 865	14 420	28 475	102 463
16	2010	155 679	2 907	15 280	28 010	109 482
17	2011	161 612	2 987	16 190	29 892	112 543
18	2012	162 769	2 798	16 179	28 773	115 019
19	2013	169 448	2 984	17 988	32 454	116 022
20	2014	183 601	2 985	19 522	35 070	126 024
21	2015	186 458	3 092	19 687	35 736	127 943
22	2016	188 974	3 032	18 960	36 949	130 033
23	2017	192 475	3 430	18 952	37 433	132 660

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

Хавсралт 2. Засгийн газрын яамдын тоо, 1992-2017

№	1992 он	№	УИХ-ын 1996.08.30-ны 40-р тогтоол	№	УИХ-ын 2000.09.01-ний 32-р тогтоол	№	УИХ-ын 2004.09.22-ны 14-р тогтоол	№	УИХ-ын 2008.12.19-ний 43-р тогтоол	№	УИХ-ын 2012.8.17-ны 14-р тогтоол	№	УИХ-ын 2016.7.21-ний 12-р тогтоол
1	Байгаль орчны яам	1	Байгаль орчны яам	1	Байгаль орчны яам	1	Байгаль орчны яам	1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	1	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2	Засаг захиргааны яам	2	Дэд бүтцийн хөгжлийн яам	2	Дэд бүтцийн яам								
3	Барилга, хот байгуулалтын яам					2	Барилга, хот байгуулалтын яам			2	Барилга, хот байгуулалтын яам	2	Барилга, хот байгуулалтын яам
4	Зам, тээвэр, холбооны яам					3	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам	2	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам	3	Зам, тээврийн яам	3	Зам, тээврийн хөгжлийн яам
5	Батлан хамгаалах яам	3	Батлан хамгаалах яам	3	Батлан хамгаалах яам	4	Батлан хамгаалах яам	3	Батлан хамгаалах яам	4	Батлан хамгаалах яам	4	Батлан хамгаалах яам
6	Шинжлэх ухаан, боловсролын яам	4	Гэгээрлийн яам	4	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	5	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	4	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	5	Боловсрол, шинжлэх ухааны яам	5	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
7	Гадаад харилцааны яам	5	Гадаад харилцааны яам	5	Гадаад хэргийн яам	6	Гадаад хэргийн яам	5	Гадаад харилцааны яам	6	Гадаад харилцааны яам	6	Гадаад харилцааны яам
8	Сангийн яам	6	Сангийн яам	6	Санхүү, эдийн засгийн яам	7	Сангийн яам	6	Сангийн яам	7	Сангийн яам	7	Сангийн яам
9	Соёлын яам									8	Соёл, спорт, аялал жуулчлалын яам		
										9	Эдийн засгийн хөгжлийн яам		
10	Худалдаа, үйлдвэрийн яам			7	Үйлдвэр, худалдааны яам	8	Үйлдвэр, худалдааны яам						
11	Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам			8	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	9	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	7	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	10	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
										11	Хөдөлмөрийн яам		
12	Хүнс, хөдөө аж ахуйн яам	7	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам	9	Хүнс, хөдөө аж ахуйн яам	10	Хүнс, хөдөө аж ахуйн яам	8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;	12	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
13	Хууль зүйн яам	8	Хууль зүйн яам	10	Хууль зүй, дотоод хэргийн яам	11	Хууль зүй, дотоод хэргийн яам	9	Хууль зүй, дотоод хэргийн яам	13	Хууль зүйн яам	10	Хууль зүй, дотоод хэргийн яам
14	Эрүүл мэндийн яам	9	Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам	11	Эрүүл мэндийн яам	12	Эрүүл мэндийн яам	10	Эрүүл мэндийн яам	14	Эрүүл мэндийн яам	11	Эрүүл мэндийн яам
15	Геологи, эрдсийн баялагийн яам									15	Уул уурхайн яам	12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
16	Түлш, эрчим хүчний яам					13	Түлш, эрчим хүчний яам	11	Эрдэс баялаг, эрчим хүчний яам	16	Эрчим хүчний яам	13	Эрчим хүчний яам
16		9		11		13		11		16		13	

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хавсралт 3. Төрийн үйлчилгээний алба, ангиллаар, 2008-2017

Он	Төрийн үйлчилгээ	Төрийн үйлчилгээ					
		Ерөнхий үйлчилгээ /ТҮ/	Шинжлэх ухаан /ТҮШУ/	Эрүүл мэнд /ТҮЭМ/	Соёл урлаг /ТҮСУ/	Мэргэжлийн боловсрол /ТҮМБ/	Бага, дунд боловсрол /ТҮБД/
2008	102553	54309	922	12680	2127	3450	29065
2009	102463	52872	1058	11651	2326	5238	29318
2010	109482	52587	1101	14657	3008	5485	32644
2011	112543	53905	1122	15106	3250	5736	33424
2012	115019	55764	1135	15381	3072	5398	34269
2013	116022	56350	1147	14921	3539	5322	34743
2014	126024	60999	1640	17073	3700	6125	36487
2015	127943	60767	1345	17702	3781	6309	38039
2016	130033	60947	1534	18077	3829	6111	39535
2017	132660	57869	1556	20151	4059	5645	43380

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

Засгийн газрын агентлагийн тоо, 1996-2016

Он	Тохируулагч агентлаг	Хэрэгжүүлэгч агентлаг	Нийт
1996	22	37	59
2000	17	31	48
2002	10	31	41
2004	14	23	37
2008	12	31	43
2012	11	17	28
2016	10	17	27

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Хавсралт 4. Шинээр баригдсан эрүүл мэндийн байгууллагууд, 2008

Эрүүл мэндийн байгууллагууд		Шинээр баригдсан эмнэлэг
"Анхдагч шатлалын эмнэлгүүд"	Бүгд	54
	Бага эмчийн ортой салбар	1
	Их эмчийн ортой салбар	1
	Өрхийн эмнэлэг	16
	Сумын эмнэлэг	30
	Сум дундын эмнэлэг	6
Хоёрдогч шатлалын эмнэлгүүд	Бүгд	4
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	1
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	3
Гуравдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	0
	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	0
	Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	0
Амаржих газрууд		0
Бусад эмнэлгүүд		0
Ортой хувийн эмнэлэг		4
Үүдэн хувийн эмнэлэг		1
Эрүүл мэндийн яам, агентлаг		0
Эрдэм шинжилгээний байгууллагууд		0
Эрүүл мэндийн газар		0
Эрүүл мэндийн нэгдэл		0
Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төв		0
Анагаах ухааны их сургууль, коллеж		0
Рашаан сувилал		0
Эм ханган нийлүүлэх байгууллага		0
Эмийн үйлдвэр		0
Эмийн эргэлтийн сан		0
Хувийн эмийн сан		0
Бусад		1
Нийт дүн		64

Хавсралт 5. Шинээр баригдсан эрүүл мэндийн байгууллагууд, 2012

Эрүүл мэндийн байгууллагууд		Шинээр баригдсан эмнэлэг
Анхдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	36
	Өрхийн эрүүл мэндийн төв	19
	Тосгоны эрүүл мэндийн төв	0
	Сумын эрүүл мэндийн төв	16
	Сум дундын эмнэлэг	1
Хоёрдогч шатлалын эмнэлгүүд	Бүгд	3
	Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв	0
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	0
	Аймаг, Дүүргийн нэгдсэн эмнэлэг	3
Гуравдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	2
	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв	2
Амаржих газрууд		1
Бусад эмнэлгүүд /Хилийн цэрэг, төмөр зам, хорихын эмнэлгүүд/		3
Ортой хувийн эмнэлэг		10
Үүдэн хувийн эмнэлэг		12
Эрүүл мэндийн яам, агентлаг		0
Эрдэм шинжилгээний байгууллагууд		0
Эрүүл мэндийн газар		1
Эрүүл мэндийн нэгдэл		0
Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төв, алба		1
Цус сэлбэлт судлалын төв, станц		0
Яаралтай тусламжийн төв		0
Анагаах ухааны сургууль, коллеж /улсын, хувийн/		1
Аршаан сувилал		3
Эм ханган нийлүүлэх байгууллага		0
Эмийн үйлдвэр		0
Хувийн эмийн сан		1
Бүгд		74

Хавсралт 6. Шинээр баригдсан эрүүл мэндийн байгууллагууд, 2016

Эрүүл мэндийн байгууллагууд		Шинээр баригдсан эмнэлэг
Анхдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	25
	Өрхийн эрүүл мэндийн төв	16
	Тосгоны эрүүл мэндийн төв	2
	Сумын эрүүл мэндийн төв	5
	Сум дундын эмнэлэг	2
Хоёрдогч шатлалын эмнэлгүүд	Бүгд	2
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	1
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1
Гуравдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	0
	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд	0
Амаржих газрууд		0
Төмөр замын салбар эмнэлгүүд		0
Ортой хувийн эмнэлэг		6
Үүдэн хувийн эмнэлэг (клиник)		12
Эрүүл мэндийн яам		0
Эрдэм шинжилгээний байгууллагууд		0
Эрүүл мэндийн газар		2
Эрүүл мэндийн хөгжлийн төв		0
Зоонозын өвчин судлалын үндэсний төв, салбар төвүүд		0
Цус сэлбэлт судлалын үндэсний төв, аймаг дүүрэг дэх цусны төвүүд		1
Яаралтай тусламжийн төв, дүүргүүд дэх салбар		0
Улсын анагаах ухааны сургууль, коллеж		0
Хувийн анагаах ухааны сургууль, коллеж		0
Сувилал		3
Эм ханган нийлүүлэх байгууллага		0
Эмийн үйлдвэр		0
Хувийн эмийн сан		6
Бусад /хилийн цэрэг, хорихын эмнэлэг, Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, төмөр замын төв эмнэлэг		4
Нийт дүн		61

Хавсралт 7. Шинээр баригдсан эрүүл мэндийн байгууллагууд, 2017

Эрүүл мэндийн байгууллагууд		Шинээр баригдсан эмнэлэг
Анхдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	12
	Өрхийн эрүүл мэндийн төв	4
	Тосгоны эрүүл мэндийн төв	1
	Сумын эрүүл мэндийн төв	7
	Сум дундын эмнэлэг	0
Хоёрдогч шатлалын эмнэлгүүд	Бүгд	3
	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	2
	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	0
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1
Гуравдагч шатлалын эмнэлгүүд	Бүгд	0
	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	0
	Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд	0
Амаржих газрууд		0
Төмөр замын салбар эмнэлгүүд		0
Ортой хувийн эмнэлэг		5
Үүдэн хувийн эмнэлэг (клиник)		5
Эрүүл мэндийн яам		0
Эрдэм шинжилгээний байгууллагууд		0
Эрүүл мэндийн газар		0
Эрүүл мэндийн хөгжлийн төв		0
Зоонозын өвчин судлалын үндэсний төв, салбар төвүүд		1
Цус сэлбэлт судлалын үндэсний төв, аймаг дүүрэг дэх цусны төвүүд		1
Яаралтай тусламжийн төв, дүүргүүд дэх салбар		0
Улсын анагаах ухааны сургууль, коллеж		0
Хувийн анагаах ухааны сургууль, коллеж		0
Сувилал		2
Эм ханган нийлүүлэх байгууллага		0
Эмийн үйлдвэр		0
Хувийн эмийн сан		0
Бусад /хилийн цэрэг, хорихын эмнэлэг, Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, төмөр замын төв эмнэлэг		1
Нийт дүн		30

Хавсралт 8. Шинээр баригдсан байгууламж, байгууллага болон өргөтгөсөн байгууламжийн тоо, 1990-2017

Сургууль

№	Он	Шинээр баригдсан байгууламжийн тоо	Шинээр байгуулагдсан байгууллагын тоо						Өргөтгөсөн байгууламжийн тоо
			Нийт	Үүнээс нийслэлд	Төрийн		Хувийн		
					Нийт	Үүнээс нийслэлд	Нийт	Үүнээс нийслэлд	
1	1990	45	2	2	2	2			4
2	1991	8	8	1	8	1			1
3	1992	17	5	3	5	3			1
4	1993	5	3	0	2		1		0
5	1994	6	4	2	1		3	2	0
6	1995	14	5	0	4		1		1
7	1996	18	4	1	1		3	1	0
8	1997	14	14	7	10	4	4	3	0
9	1998	21	16	9	9	3	7	6	0
10	1999	7	14	10	2		12	10	2
11	2000	27	13	7	6	2	7	5	1
12	2001	23	5	1	3		2	1	6
13	2002	25	8	3	1		7	3	4
14	2003	34	6	3	4	1	2	2	2
15	2004	32	6	2	2		4	2	4
16	2005	37	5	4			5	4	11
17	2006	40	12	5	5	1	7	4	4
18	2007	44	11	3	7	2	4	1	12
19	2008	55	3	1	2		1	1	10
20	2009	68	9	3	7	2	2	1	21
21	2010	48	8	5	6	3	2	2	12
22	2011	48	7	6	5	4	2	2	9
23	2012	60	5	3	4	2	1	1	15
24	2013	53	10	4	8	3	2	1	18
25	2014	79	15	9	10	5	5	4	17
26	2015	80	24	12	17	7	7	5	7
27	2016	68	15	10	8	4	7	6	1
28	2017	24	23	20	8	5	15	15	2
БҮГД		1000	147	136	147	54	113	82	165

Эх үүсвэр: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын яам

Хавсралт 9. Шинээр байгуулагдсан байгууламж, байгууллага болон өргөтгөсөн байгууламжийн тоо,1990-2017

Цэцэрлэг

№	Он	Шинээр баригдсан байгууламжийн тоо	Шинээр байгуулагдсан байгууллагын тоо			Өргөтгөсөн байгууламжийн тоо
			Улсын тоо			Төрийн
			Нийт	Төрийн	Хувийн	
1	1990	29	-	-	-	-
2	1991	10	-	-	-	-
3	1992	11	-	-	-	-
4	1993	3	-	-	-	-
5	1994	3	-	-	-	-
6	1995	2	-	-	-	-
7	1996	1	-	-	-	-
8	1997	2	-	-	-	-
9	1998	5	-	-	-	-
10	1999	3	-	-	-	-
11	2000	7	-	-	-	2
12	2001	10	-	-	-	-
13	2002	5	-	-	-	-
14	2003	14	-	-	-	2
15	2004	18	-	-	-	1
16	2005	25	-	-	-	-
17	2006	34	-	-	-	-
18	2007	38	-	-	-	1
19	2008	59	-	-	-	3
20	2009	49	31	16	15	2
21	2010	75	25	10	15	2
22	2011	58	40	12	28	3
23	2012	133	66	16	50	5
24	2013	121	122	14	108	3
25	2014	127	104	13	91	13
26	2015	171	117	49	68	9
27	2016	115	66	28	38	12
28	2017	92	62	24	38	19
БҮГД		1220	633	182	451	77

Эх үүсвэр: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын яам

Хавсралт 10. Шинээр байгуулагдсан байгууламж, байгууллага болон өргөтгөсөн байгууламжийн тоо, 1990-2017

Соёл

№	Он	Шинээр баригдсан байгууламжийн тоо				Шинээр байгуулагдсан байгууллагын тоо	Өргөтгөсөн байгууллага, байгууламжийн тоо
		Музей	Соёлын төв	Номын сан	Театр		
1	1990	-	-	-	-	-	-
2	1991	-	-	-	-	-	-
3	1992	-	-	-	-	-	-
4	1993	-	-	-	-	-	-
5	1994	-	-	-	-	-	-
6	1995	-	-	-	-	-	-
7	1996	-	-	-	-	-	-
8	1997	-	-	-	-	-	-
9	1998	-	-	-	-	-	-
10	1999	-	-	-	-	-	-
11	2000	-	-	-	-	-	-
12	2001	-	-	-	-	-	-
13	2002	-	-	-	-	-	-
14	2003	-	-	-	-	1	-
15	2004	-	-	-	-	-	-
16	2005	-	-	-	-	-	-
17	2006	-	-	-	-	-	-
18	2007	-	-	-	-	-	-
19	2008	-	6	-	-	-	-
20	2009	2	17	-	-	-	-
21	2010	1	10	1	1	1	-
22	2011	1	8	-	1	-	-
23	2012	1	-	-	-	-	-
24	2013	-	-	1	-	-	-
25	2014	-	-	1	-	-	1
26	2015	-	10	-	1	-	-
27	2016	-	4	-	-	-	-
28	2017	-	1	1	-	-	-
БҮГД		5	56	4	3	2	1

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

**Хавсралт 11. Шинээр байгуулагдсан байгууламж, байгууллага болон өргөтгөсөн байгууламжийн тоо,
1990-2017**

Шинжлэх ухаан

№	Он	Шинээр баригдсан байгууламжийн тоо	Шинээр байгуулагдсан байгууллагын тоо	Өргөтгөсөн байгууллага, байгууламжийн тоо
1	1990	0	0	
2	1991	0	0	
3	1992	0	0	
4	1993	0	0	
5	1994	0	0	
6	1995	0	0	
7	1996	0	0	
8	1997	0	0	
9	1998	0	0	
10	1999	0	0	
11	2000	0	0	
12	2001	0	0	
13	2002	0	0	
14	2003	0	0	
15	2004	0	0	
16	2005	0	0	
17	2006	0	0	
18	2007	0	0	
19	2008	0	0	
20	2009	0	0	
21	2010	0	0	1
22	2011	0	0	
23	2012	0	0	
24	2013	0	0	
25	2014	0	0	
26	2015	0	0	
27	2016	0	0	
28	2017	0	1	1
БҮГД			1	2

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Хавсралт 12. Шинээр байгуулагдсан байгууламж, байгууллага болон өргөтгөсөн байгууламжийн тоо,1990-2017

Спорт

№	Он	Шинээр баригдсан байгууламжийн тоо	Шинээр байгуулагдсан байгууллагын тоо	Өргөтгөсөн байгууллага, байгууламжийн тоо
1	1990	20	20	
2	1991	6	6	
3	1992	6	6	
4	1993	1	1	
5	1994	3	3	
6	1995	2	2	
7	1996	5	5	
8	1997	7	7	
9	1998	3	3	
10	1999	9	9	
11	2000	10	10	
12	2001	6	6	
13	2002	13	13	
14	2003	14	14	
15	2004	12	12	
16	2005	16	16	
17	2006	15	15	
18	2007	15	15	
19	2008	28	28	
20	2009	29	29	
21	2010	24	24	
22	2011	29	29	
23	2012	34	34	
24	2013	38	38	
25	2014	43	43	
26	2015	49	49	
27	2016	44	44	
28	2017	51	51	
29	БҮГД	532	532	

Эх үүсвэр: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын яам